

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН  
Т У Ш А А Л

1995 оны 09 дүгээр  
сарын 24-д өдөр

дугаар

А/200  
А/146

Улаанбаатар  
хот

Яслийн хэв шинж бүтцийг  
өөрчлөх, цэцэрлэг яслийн  
цогцолборт дугаар олгох  
тухай

1. Монгол улсын Боловсролын хуулийн Сургуулийн өмнөх бага, дунд боловсролын тухай 2,3 дугаар бүлгийн 8, 11 дүгээр зүйл, яслийн орны ашиглалтыг сайжруулах, бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 22, 13 дугаар яслиудыг энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэв шинж бүтцийг өөрчлөн цэцэрлэг яслийн цогцолбороор ажиллуулсугай.

2. Дээрх яслиудын барилга, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг Боловсролын газар \П.Дорж\ -т балансаас балансад шилжүүлэхийг Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\ -т даалгасугай.

3. Хотын Эрүүл мэндийн газраас шилжүүлсэн яслиудад 1 дүгээр хавсралт ёсоор цэцэрлэг-яслийн цогцолборын дугаар олгож ажиллуулахыг Боловсролын газар \П.Дорж\ -т даалгасугай.

4. Цогцолбороор ажиллах цэцэрлэг яслийн төсөв төлөвлөгөөг зохицуулалт хийхийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хэлтэс \Д.Гонгор\, Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\, Боловсролын газар \П.Дорж\, Дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Цогцолбороор ажиллах цэцэрлэг яслийн орон тоогоор илүүдэж байгаа ажилчдыг хөдөлмөрийн хуулийн дагуу ажлаар хангахыг Боловсролын газар \П.Дорж\, Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\, Дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Сургуулийн өмнөх насны хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалж эрүүлжүүлэн чийрэгжүүлэхэд мэргэжлийн хяналт тавьж туслалцаа үзүүлж хамтарч ажиллахыг Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\ -т даалгасугай.


7. Хүүхдийн цэцэрлэг, яслийн одоогийн бүтэц өрхион байгуулалт, хэв шинжийг өөрчлөн шинэчлэнх саналаа боловсруулж 1996 оны 1 улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд оруулахыг Боловсролын газар \П.Дорж\, Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\ -т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БЭГВЭД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц. БААСАНЖАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

П. НИЯМДАВАА



ШИНЭЭР ОЛГОСОН ЦЭЦЭРЛЭГ ЯСЛИЙН  
ЦОГЦОЛБОРЫН ДУГААР

-----

Яслийн дугаар : Шинээр олгосон дугаар

-----

- 1. 13 дугаар ясли 29 дүгээр цэцэрлэг яслийн цогцолбор
- 2. 22 дугаар ясли 30 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор

-----